



“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”  
ХХК-Д

## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 05. 22 № 03/4203  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ТТЗ/20240202239 дугаартай “Зам төмрийн жийрэг худалдаж авах” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Брэнд теч бридж” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Брэнд теч бридж” ХХК-ийн гомдолд “Есөнмөнх сүлд” ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.2-т заасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт ирүүлээгүй, ТШЗ 18.2-т заасан түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх шаардлага хангаагүй байхад гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Есөнмөнх сүлд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.2-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг цахим хэлбэрээр авна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ” гэж заасан байна.

“Есөнмөнх сүлд” ХХК нь тендерт иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт, мөн сүүлийн 3 жилийн байдлаар иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй тухай тодорхойлолт ирүүлсэн байх тул дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Түүнчлэн тендер шалгаруулалтын баримт бичигт Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт ирүүлэх шаардлага заагаагүй тул тус тодорхойлолттой холбоотой аливаа асуудлыг тендерийн үнэлгээнд харгалзан үзэхгүй болохыг анхаарна уу.

9766007331

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2-т "Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг: ... Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ төсөвт өртгийн үнийн дүнгийн 100 хувиас багагүй байх ба дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр тодорхойлно. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/, Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Судалж зээл олгох боломжтой гэх утга бүхий тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй" гэж заажээ.

"Есөнмөнх сүлд" ХХК нь тендерт Худалдаа хөгжлийн банкны 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн тус компанид 15,000,000.0 төгрөгийг зээл олгох боломжтой тухай тодорхойлолт, мөн банканд 15,146,669.54 төгрөгийн үлдэгдэлтэй тухай тодорхойлолтыг тус тус ирүүлсэн байна. Уг тодорхойлолтууд нь дээр дурдсан шаардлагад нийцэх эсэхэд захиалагч үнэлгээ хийгээгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 1/1296 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Брэнд теч бридж" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, appearing to read 'Ж. ГАНБАТ', is enclosed within a rectangular stamp border. The signature is stylized and cursive.

Ж.ГАНБАТ